



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 1 өдөр

Дугаар А/177

Хэрлэн сум

**Генерал цолтнуудад хүндэтгэл
үзүүлэх, хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.13 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад цэргийн дээд цол олгож эхэлсний 80 жилийн ойг тохиолдуулан Хэнтий аймгаас төрөн гарсан генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй, урьдчилан төлөвлөх боломжгүй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

3. Генерал цолтнуудын түүхэн замнал, алдар гавьяаг сурталчлах арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Л.Цэнддорж)-д даатгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ